



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/89

Хархорин сум

**Бүх нийтийн цэвэрлэгээ зохион
байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгшин Орхон голын ай сав газрын хог цэвэрлэгээг 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсугай.

2.Албан байгууллагуудын цэвэрлэгээ хийх байршлыг хавсралтаар баталж, цэвэрлэгээний ажилд албан хаагчдаа оролцуулахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3.Хог хаягдлыг ачиж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх ажлыг зохион байгуулахыг байгууллагын дарга, эрхлэгч нар болон Хотын захирагчийн албаны ерөнхий менежер (Г.Лхагвабуд)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Ц.Баатарсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ